



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Архангай аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 25,320,000.00 (хорин таван сая гурван зуун хорин мянган) төгрөгийн балансын үнэ, 19,480,853.38 (арван есөн сая дөрвөн зуун наян мянга найман зуун тавин гурван төгрөг гучин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Архангай аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Д.Тунгалаг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4.Авсан арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Д.АРИУНБОЛД

0000288

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 5 дугаар сарын 07-ний өдрийн
140 дугаар тогтоолын хавсралт



Архангай аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Автомашинны гарааш	1975	Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 5-р баг цагаан хаалганы баруун урд	2,363,200.00	2,363,200.00	0
2	Өвөлжөө	2008	Архангай аймаг, Цэнхэр сум, Буйлан баг	3,238,400.00	1,781,119.97	1,457,280.03
3	Тахианы байр	2005	Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 5-р баг цагаан хаалганы баруун урд	19,718,400.00	15,336,533.41	4,381,866.59
	Нийт дүн			25,320,000.00 (хорин таван сая гурван зуун хорин мянган)	19,480,853.38 (арван есөн сая дөрвөн зуун наян мянга найман зуун тавин гурван төгрөг гучин найман мөнгө)	5,839,146.62 (таван сая найман зуун гучин есөн мянга нэг зуун дөчиг зургаан төгрөг жаран хоёр мөнгө)